



ДУНДГОВЬ АЙМАГ  
АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 01 өдөр

Дугаар 1/01

Тавин

Тамга, тэмдэг түших, хэвлэмэл  
хуудас хариуцсан ажилтныг  
томилох тухай

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 39 дүгээр зүйл, Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын 4.1.2, 4.1.3, 4.3.1, 4.3.2, 4.3.3 дахь заалтууд, Засгийн газрын 2021 оны 08 сарын 04-ний өдрийн 226 дугаар тогтоолоор батлагдсан "Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам"-ын 6.7, 6.18 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын тамга, тэмдэг, хэвлэмэл хуудсыг хариуцах ажилтнаар Архив, бичиг хэргийн ажилтан Норовсайханы Цэрэнчунтыг томилсугай.
2. Засаг даргын Тамгын газрын даргын 2015 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/26 дугаартай "Тамга, тэмдэг түших хэвлэмэл хуудсыг хариуцах тухай" тушаалыг хүчингүй болгосугай.
3. Байгууллагын тамга, тэмдэг, хэвлэмэл хуудсыг заавар журмын дагуу хэрэглэж, хадгалалт, хамгаалалтыг сайжруулан ажиллахыг тамга, тэмдэг түших хэвлэмэл хуудас хариуцсан ажилтанд үүрэг болгосугай.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *Ж.ОЧИРБАТ* Ж.ОЧИРБАТ

